

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр

Тендерийн нэр: “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол

Тендер дугаар: МРЦМ/202212229

“Монголросцветмет” ТӨҮГазар болон “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгж нь Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төвийн Техник эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэхээр төлөвлөж байгаа тул уул уурхайн объектын ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх тухай санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймгийн Бэрхийн ордод суурилсан “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгжийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулж, тус ордыг түшиглэн далд уурхайн музей бүхий эрдэс баялагийн салбарын мэргэжлийн боловсон хүчний сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв байгуулах замаар Монгол улсад уул уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн жишиг тогтоох, түүнийг олон улсын хэмжээний жишигт хүргэх, мөн түүнчлэн Монгол улсын Зүүн бүсийн түүхэн аялал жуулчлалын маршрутад оруулах, шинээр ажлын байр бий болгоход чиглэгдэнэ.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх санал ирүүлж буй этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2019, 2020, 2021 (Сүүлийн гурван жилд заагдсан зөвлөх үйлчилгээний чиглэлээр хийж гүйцэтгэсэн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Уул уурхайн объектын барилга байгууламж, металл хийцийн даацын судалгаа, хүн ачаа өргөх, тээвэрлэх машин механизмын чиглэлээр тооцоо, зураг, төсөл боловсруулах чадвартай боловсон хүчинтэй байх
- Уул уурхайн барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах ажлын гурван жилээс багагүй туршлагатай байх
- Тусгай зөвшөөрөл: Барилгын ажлын зураг төсөл, төсөв боловсруулах

Чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно. Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон хуулийн этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө дор дурдсан хаягаар ажлын өдрийн 09.00-15.00 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 10:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГазар

“Монголын далд уурхайн сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгж

Хаяг: Улаанбаатар хот-51, ш/х-002

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 98

“Монголросцветмет”ТӨҮГ